Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	8,877.8	8,877.8
Авлага	31.6	0.00	-31.6
Бараа материал	12,637.0	20,801.7	8,164.6
Үндсэн хөрөнгө	1,180,064.7	1,148,650.6	-31,414.1
Нийт хөрөнгө	1,192,733.3	1,178,330.1	-14,403.2
Өр төлбөр	22.3	511.3	489.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,192,711.0	1,177,818.7	-14,892.3

Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,192,733.3	1,178,330.1	-14,403.2
---------------------------------------	-------------	-------------	-----------

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 8,877.8 мянган төгрөг байгаа нь зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлгүй болж 31.6 мянган төгрөгөөр буурсан нь авлагыг барагдуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 20,801.7 мянган төгрөг болж 8,164.6 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, бичиг хэргийн материалын худалдан авч нөөцөлснөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,148,650.6 мянган төгрөг болж 31,414.1 мянган төгрөгөөр буурсан нь машин тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг акталж данснаас хассан, номыг балансаас балансад шилжүүлсэн, хөрөнгийн хуримтлагдсан элэгдлээс шалтгаалж буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,177,818.7 мянган төгрөг болж 14,892.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 238,536.0 мянга, орон нутгийн төсвөөс 76,979.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжих зардлыг 20,063.9 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжих зардлыг 14,913.2 мянган төгрөгийг хасаж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс санхүүжих зардлыг 218,472.1 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжих зардлыг 62,066.2 мянган төгрөгөөр батлагдсаны тодотголоор улсын төсвөөс санхүүжих зардлыг 216,792.1 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжих зардлыг 62,066.2 мянган төгрөгөөр баталжээ.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 216,792.1 мянга орон нутгийн төсвөөс 62,066.6 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс орон нутгийн төсвөөс 226,152.1 мянга, орон нутгийн төсвөөс 62,066.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 279,340.9 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 8,877.8 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702 Соёл урлаг Үндсэн үйл ажиллагааны зардал- 80101	205,962.9	226,152.1	20,189.2	109,8%
2	Ажил олгогч 80802	10,189.2	10,059.4	129.8	98.7%
3	Эрдэм шинжилгээ 80215	10,000.0	8,558.9	1,441.1	85.5%
4	Дээд шат нэмэлт 83603	14,750.0	9,338.0	5,412.0	63.3%
5	Орон нутгийн төсвийн тогтмол зардал /80111/	62,066.6	61,728.3	338.3	99.4%

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал нь албан хаагч ажлаас чөлөөлөгдсөнөөс шалтгаалан 1,896.3 мянга, байр ашиглалтын зардал 2,536.2 мянга, дотоод албан томилолт 352.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 129.8 мянган төгрөгийг Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотойгоор тус тус хэмнэсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

АНУ-ын элчин сайдын яамны төсөл хөтөлбөрөөр 29,270.9 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 14,913.2 мянга, нийт 44,184.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Үүнээс Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, шимтгэлийн зардал 20,207.1 мянга, хангамж бараа материалын зардалд 12,032.7 мянга, эд хогшил худалдан авахад 7,339.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 2,026.0 хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 711.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	АНУ-ын Элчин сайдын яам	2022 он	100%	93%	29,270.9	27,402.9

Англи хэлний сургалтын танхим тохижуулах ажил дутуу хийгдэж 1,868.0 мянган төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор С.Алтанхундага гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 388,086.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,880.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 359,148.1 төгрөгийн 1 хувиар буюу 3,573.3 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн материалыг байдлыг 80 хувиар тооцож 2,873.2 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Нийтийн номын сангийн хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 119 мэдээллээс, хугацаа хоцроож мэдээлсэн 3, мэдээлэл байршуулаагүй 9, хугацаандаа мэдээлсэн 107 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийтийн номын сан нь нийт 9 мэдээлэл, 82,416.7 мянган төгрөгийн гүйлгээг шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй зөрчилд албан шаардлага өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Увс аймгийн Нийтийн номын сангийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал нь батлагдсан орон тоондоо багтаж ажиллаж байгааг анхаарах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,964.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7,918.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,045.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага өглөө.

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэж заасныг зөрчин 7,918.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн алдааг залрууллаа.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТЦУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЭТ АУДИТОР  /С.АЛТАНХУНДАГА/

2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр

АЛБАН ШААРДЛАГЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХУУДАС

А. Албан шаардлагын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1. Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Увс аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	УВА-2023/33/НА-СТА-ТШЗ
-----------------	--	-----------------	------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын газрын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	--	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлагын дугаар	01/06 А2050409 УВА-2023/33/НА-СТА-ТШЗ	1.6 Огноо	2023.02.16	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	2,045,450.00
-----------------------------	--	-----------	------------	----------------------------	--------------

1.8 Албан шаардлага өгөх үндэслэл	Алдаа, зөрчлийн товч утга	Увс аймгийн Нийтийн номын сан нь Соёлын сайдын 2022 оны баталсан орон тоог зөрчин Нийтийн номын сангийн захирлын 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 28 дугаар тушаалаар архив, бичиг хэргийн ажилтан, нярав шинээр нэмж томилон 2,045,450 төгрөгийн цалин олгож төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан			
	Алдаа, зөрчлийн ангилал	Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой.			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хууль,		
		Заалт	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2-т "Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох		
Үндэслэл болгосон	Нэр	Төрийн аудитын тухай хууль			

	эрх зүйн актын	Заалт	Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.
		Нэр	Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам
		Заалт	Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.6-дахь заалтад "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан"

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр /Төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд	-	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд	-	
	Тухайн байгууллагын дансанд	2,045,450.00	
			2023-03-30

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Цалингийн баримт	10.11.12	2022.11.30 2022.12.22	10,11,12-р сард цалин олгосон
2	Номын сангийн архив бичиг хэргийн ажилтан, няраваар томилсон тушаал	28	2022,10,06	

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			
	Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	М.Батсуурь	Дарга, тэргүүлэх аудитор	Увс аймгийн Нийтийн номын сангийн	захирал	Б.Батхүү	99058211
2	М.Бат-Амгалан	Аудитын менежер		Нягтлан бодогч	Ц.Сэлэнгэ	90180288
	С.Алтанхундага	Гэрээт аудитор				


4. Албан шаардлага бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
---	-----------------	-------	---------------------------------------	------------

1	Дарга, тэргүүлэх аудитор	2023.02.16	—
2	Аудитын менежер	2023.02.16	—

4.2 Албан шаардлагыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Дарга, тэргүүлэх аудитор	М.Батсуурь	2023.02.16	

5. Албан шаардлагыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг	Тайлбар	
1	Албан шаардлагыг баталгаажуулсан тушаалын	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлагыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлагыг хүлээлгэн өгсөн	Огноо		
		Ажилтны	Овог нэр	С.Алтанхундага
			Албан тушаал	Гэрээт аудитор
4	Албан шаардлагыг хүлээн авсан	Байгууллагын нэр		Увс аймгийн Нийтийн номын сан
		Ажилтны	Овог нэр	Ц.Сэлэнгэ
			Албан тушаал	Нягтлан бодогч
5	Албан шаардлагын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр		Увс аймаг дахь Төрийн аудитын газар
		Ажилтны	Овог нэр	С.Алтанхундага
			Албан тушаал	Гэрээт аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		1



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 01/06/А2050409
УВА-2023/33/НА - СГА-ТЦЗ

Улаангом

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Увс аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Увс аймгийн Нийтийн номын сан нь Соёлын сайдын 2022 оны баталсан орон тоог зөрчин Нийтийн номын сангийн захирлын 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 28 дугаар тушаалаар архив, бичиг хэргийн ажилтан, нярав шинээр нэмж томилон 2,045,450 төгрөгийн цалин олгож төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2-т “Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтад “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” 4.2.1.6-дахь заалтад “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Батлагдсан орон тоог хэтрүүлэн архив, бичиг хэрэг, нярав ажиллуулж 2,045,450 төгрөгийн цалин олгож төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар² т ирүүлэх.

²Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317

6200400020

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Увс аймгийн Нийтийн номын сангийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батхүү, нягтлан бодогч Ц.Сэлэнгэ нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГЭРЭЭТ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.АЛТАНХУНДАГА

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ

АЛБАН ШААРДЛАГЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХУУДАС

А. Албан шаардлагын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1.Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Увс аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	УВА-2023/33/НА-СТА-ТШЗ		
1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын газрын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит		
1.5 Албан шаардлагын дугаар	02/12/A2050409 УВА-2023/33/НА- ЭТА-ТШЗ	1.6 Огноо	2023.02.24	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	82,416,700

1.8 Албан шаардлага өгөх үндэслэл	Алдаа, зөрчлийн товч утга	Нийтийн номын сан нь Шилэн дансны цахим хуудаст 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 82,416.7 мянган төгрөгийн 9 мэдээллийг байршуулаагүй байна.			
	Алдаа, зөрчлийн ангилал	Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой.			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Шилэн дансны тухай хууль,		
		Заалт	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” 6.4.8 дахь заалтад “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”		
Үндэслэл болгосон	Нэр	Төрийн аудитын тухай хууль			

	эрх зүйн актын	Заалт	Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.
		Нэр	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам
		Заалт	Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.6-дахь заалтад "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан"

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр /Төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд	-	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд	-	
	Тухайн байгууллагын дансанд	0.00	
			2023-03-30

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Шилэн дансны мэдээлэл		2022,10,11,12 сар	
2				

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			
	Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	М.Батсуурь	Дарга, тэргүүлэх аудитор	Увс аймгийн Нийтийн номын сангийн	захирал	Б.Батхүү	99058211
2	М.Бат-Амгалан	Аудитын менежер		Нягтлан бодогч	Ц.Сэлэнгэ	90180288
	С.Алтанхундага	Гэрээт аудитор				


4. Албан шаардлага бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг

1	Дарга, тэргүүлэх аудитор	2023.02.24	-
2	Аудитын менежер	2023.02.18	-

4.2 Албан шаардлагыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Дарга, тэргүүлэх аудитор	М.Батсуурь	2023.02.24	

5. Албан шаардлагыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг	Тайлбар	
1	Албан шаардлагыг баталгаажуулсан тушаалын	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлагыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлагыг хүлээлгэн өгсөн	Огноо		
		Ажилтны	Овог нэр	С.Алтанхундага
			Албан тушаал	Гэрээт аудитор
4	Албан шаардлагыг хүлээн авсан	Байгууллагын нэр		Увс аймгийн Нийтийн номын сан
		Ажилтны	Овог нэр	Ц.Сэлэнгэ
			Албан тушаал	Нягтлан бодогч
5	Албан шаардлагын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр		Увс аймаг дахь Төрийн аудитын газар
		Ажилтны	Овог нэр	С.Алтанхундага
			Албан тушаал	Гэрээт аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		1



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 02/12/А.2050409

Улаангом

УВА-2023/33/НА-ОАА ТУМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийтийн номын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийтийн номын сан нь Шилэн дансны цахим хуудаст 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 82,416.7 мянган төгрөгийн 9 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” 6.4.8 дахь заалтад “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтад “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөн ажиллаж биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт² ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийтийн номын сангийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батхүү, нягтлан бодогч Ц.Сэлэнгэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГЭРЭЭТ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.АЛТАНХУНДАГА

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ